

11

ГАДААД ВАЛЮТЫН ХАНШНЫ ӨӨРЧЛӨЛТИЙН БҮРТГЭЛ, ТАЙЛАГНАЛ

Д. Нямаа

Салбар, хэсэг, санхүүжигч болон охин компаниудаараа дамжуулан нэгээс дээш гадаад улс оронд үйл ажиллагаагаа явуулдаг бизнесийн нэгжийг үндэстэн дамнасан корпораци гэдэг билээ. Үндэстэн дамнасан корпорацийн гадаад дахь салбар, хэсгүүдийн үйл ажиллагааны бүртгэл, тайлагналын үндсэн асуудал нь арилжаанд ямар ханшийг хэрэглэх болон гадаад валютын ханшны өөрчлөлтийн үр нөлөөг санхүүгийн тайланд хэрхэн тусгах вэ? гэдгийг шийдвэрлэхэд оршдог юм.

Үндэстэн дамнасан корпорацийн төв нь гадаадын бие даасан компаниуд болон гадаад дахь салбар, хараат, охин компаниудтайгаа худалдаа, зээлийн харилцаанд байнга ордог бөгөөд тухайн ажил гүйлгээ нь төв компанийн тайлан валютаар хийгдсэн тохиолдолд бүртгэлийн ямар нэгэн бэрхшээлтэй асуудал тулгарахгүй. Харин ажил гүйлгээ гадаад валютаар хийгдсэн үед гадаад валютаарх ажил гүйлгээний дүнг үндэсний валютад шилжүүлж бүртгэх шаардлага гарна. Хоёр улсын валютын солилцооны ханшийг ашиглан гадаад валютыг үндэсний валютаар илэрхийлж бүртгэх ба үүнийг гадаад валют хөрвүүлэлт гэж нэрлэдэг.

Гадаад валют нь ихэнх улс орнуудад бараа болон мөнгөний зах зээлийн хэрэгсэл адилаар тооцогддог. Валютын солилцооны ханшны өөрчлөлтөөс шалтгаалж худалдах болон худалдан авах үнэ тогтоогдох ба валютыг худалдах ба худалдан авах гүйлгээ хийгдэнэ.

Жишээлбэл: Британийн фунтийн солилцооны ханшийг доорх байдлаар харуулж болох юм. Үүнд:

Фунтын доллараар илэрхийлэгдсэн ханш	Долларын фунтээр илэрхийлэгдсэн ханш
1,6025	0,6225

Энд 1 фунт ойролцоогоор 1,61 \$-аар арилжигдаж болох, харин 1 доллар ойролцоогоор 0,62 фунтээр арилжаалагдаж болохыг харуулж байна. Дээрх арилжааны ханш нь

солилцооны спот ханш буюу тухайн өдрийн ханш бөгөөд банкны гадаад валют худалдан авах өнөөгийн ханш юм.

Валютын тухайн өдрийн ханшнаас гадна ирээдүйн гадаад валютын ажил гүйлгээнд хэрэглэх гэрээгээр тохиролцсон ханш буюу форвард ханшийг бүртгэлд ашигладаг.

Гадаад валютаарх ажил гүйлгээ болон гадаад валютын ханшны өөрчлөлтийг бүртгэлд хэрхэн тусгахыг жишээгээр авч үзье.

Спот ханш

Тайлант жилийн 9 сарын 16-нд "Мана" ХХКомпани Америкийн "USTrade" компанид 15000 ам. долларын худалдах үнэтэй барааг 30 хоногийн хугацаатай зээлээр борлуулсан. 16/IX-нд 1 ам. доллар = 1000₮ байв. Тэгвэл "Мана" компанийн бүртгэлд дараах бичилт хийгдэнэ. Үүнд:

Дт Худалдааны авлага	15 000 000	
Кт Борлуулалтын орлого		15000000
	(15000\$*1000₮)	

Зээлийн хугацаанд авлагаас мөнгө төлөгдөж ирээгүй бөгөөд ам. долларын худалдах спот ханш өөрчлөгдсөн. 30/IX өдөр буюу санхүүгийн тайлангийн тасалбар болгосон өдөр 1 ам. доллар = 1100₮ болов. Энэ тохиолдолд компани ханшийн зөрүүний олзыг хүлээн зөвшөөрч

Дт Худалдааны авлага	1500000	
Кт Ханшийн зөрүүний олз		1500000
	(1100₮-1000₮)*15000\$	

гэсэн бичилтийг хийнэ.

16/IX-нд	бүртгэгдсэн авлага	15000000₮
30/IX-нд	15000\$*1100₮ ханшаар хөрвүүлсэн авлага	16500000₮
	Ханшийн зөрүүний олз	1500000₮

16/IX-нд ам. долларын худалдах спот ханш буурч 1 ам. доллар = 1060₮ болсон ба "US Trade" компаниас төлбөр төлөгдөж ирсэн гэвэл.

Дт Ханшийн зөрүүний гарз	600000	
Кт Худалдааны авлага		600000
	(1100₮-1060₮) * 15000\$	
Дт Мөнгөн хөрөнгө	15900000	
Кт Худалдааны авлага		15900000

гэсэн бичилтийг тус тус хийнэ.

Дээрх ажил гүйлгээнээс үүссэн ханшийн зөрүүний олз (гарз)-ыг Орлогын тайлангийн үйл ажиллагааны бус орлого (зардал) хэсэгт тайлагнана.

Форвард солилцооны гэрээ

Форвард солилцооны гэрээ нь гадаад валютаарх ажил гүйлгээний өөр нэг төрөл юм. Энэ нь ирээдүйн өдөр гадаад улс орнуудын валютыг солилцоходоо тогтсон форвард ханшийг хэрэглэхээр тохиролцсон хэлэлцээрийг хэлнэ.

2001 оны 3 сарын 5-нд Германы компаниас 60 хоногийн хугацаатай гэрээгээр 50000 DM авахаар болов. Гэрээ хийсэн өдрийн 1DM-н төгрөгтэй харьцах спот ханш 380₮, форвард ханш 405₮ байсан гэвэл:

3 сарын 5-нд

Дт: Форвард солилцооны гэрээний авлага	19000000
(50000 DM*380₮)	
Дт: Форвард солилцооны гэрээний өглөгийн хөнгөлөлт	1250000
(50000 DM*(405-380₮))	
Кт: Форвард солилцооны гэрээний өглөг	20250000
(50000 DM*405₮)	

гэж бичнэ.

Гэрээний хугацаанд DM-н спот ханш өөрчлөгдвөл ханшийн зөрүүний олз гарзыг бүртгэнэ. Учир нь авлагын өнөөгийн үнэ өөрчлөгдөнө.

3 сарын 30-нд 1DM=375₮ болов. Энэ үед дараах бичилт хийгдэнэ.

Дт: Ханшийн зөрүүний гарз	250000
(50000*(380-375))	
Дт: Хүүний зардал (25/60*1250000)	520833
Кт: Форвард солилцооны гэрээний авлага	250000
Кт: Форвард солилцооны гэрээний өглөгийн хөнгөлөлт	520833

5 сарын 4-нд гэрээний эцсийн өдөр DM-н төгрөгтэй харьцах ханш 378₮ болсон бол бүртгэлд

1. Форвард солилцооны гэрээний авлага	150000
(50000*(380-375))	
Хүүний зардал (35/60*1250000)	729167
Ханшийн зөрүүний олз	150000
Форвард солилцооны гэрээний өглөгийн хөнгөлөлт	729167
2. Форвард солилцооны гэрээний өглөг	20250000
Мөнгөн хөрөнгө	20250000
3. Мөнгөн хөрөнгө (DM)	18900000
Форвард солилцооны гэрээний авлага	18900000

гэж бичнэ.

Санхүүгийн тайланд Форвард солилцооны гэрээний өглөг болон түүний хөнгөлөлтийг балансын богино хугацаат өглөг хэсэгт, Форвард солилцооны гэрээний авлагыг эргэлтийн хөрөнгөнд тус тус тайлагнана.

Гадаад дахь аж ахуйн нэгжийн санхүүгийн тайлан

Үндэстэн дамнасан корпораци санхүүгийн тайлангаа нэгтгэж гаргахдаа гадаад дахь салбар эсвэл хараат охин компанийхаа хөрөнгө, өр төлбөр, үйл ажиллагааг нэгтгэх бөгөөд ингэхдээ тухайн гадаад дахь аж ахуйн нэгжийн санхүүгийн тайланд тусгагдсан дүнг өөрийн үндэсний валютаар хөрвүүлэх ёстой. Валютын солилцооны ханш ихэнхдээ өөрчлөгдөж байдаг учраас санхүүгийн тайланг хөрвүүлэхэд солилцооны ямар ханшийг ашиглах нь зүйтэй вэ? гэсэн асуудал нягтлан бодогчдын өмнө тулгардаг. Гадаад валютыг хөрвүүлэхэд дараах үндсэн 4 аргыг ашиглана. Үүнд :

- 1-рт: Хөрөнгө, эх үүсвэрийн балансын ангиллаас хамааруулан хөрвүүлэх арга (current, noncurrent)
- 2-рт: Хөрөнгийн шинж байдлаас хамааруулан хөрвүүлэх арга (monetary nonmonetary)

3-рт: Тухайн үеийн ханшны арга (current rate)

4-рт: Цаг үеийн арга (Temporal)

Хөрөнгө эх үүсвэрийн баланс дахь ангиллын арга

Энэ аргаар хөрвүүлэхдээ, эргэлтийн хөрөнгө болон богино хугацаат өр төлбөрийг гадаад дахь аж ахуйн нэгжийн баланс гаргасан өдрөөрх буюу тухайн үеийн (current rate) ханшаар, бусад бүх хөрөнгө, өр төлбөр, эзний өмчийн элементүүдийг анх, уг гадаад аж ахуйн нэгжид хөрөнгө, өр төлбөр, эзний өмч хүлээн зөвшөөрөгдсөн тэр өдрөөрх буюу анхны (historical rate) ханшаар тус тус хөрвүүлнэ. Харин орлогын тайланд элэгдлийн болон биет бус хөрөнгийн хасагдуулгын зардлыг хөрвүүлж харуулахдаа холбогдох хөрөнгүүдийн анхны ханшаар, бусад орлого, зардлуудыг бүртгэлийн хугацааны дундаж солилцооны ханшаар (average exchange rate) хөрвүүлнэ.

Хөрөнгийн шинж байдлаас хамааруулах арга

Энэ аргын мөн чанар нь гадаад аж ахуйн нэгжийн хөрөнгө өр төлбөрийн баланс дахь ангиллаас илүүгээр хөрөнгө эх үүсвэрийн шинж байдлаас хамааруулж хөрвүүлэх явдал юм.

Хөрвүүлэхдээ мөнгөн хөрөнгө ба өр төлбөрийг тухайн үеийн солилцооны ханшаар, бусад бүх хөрөнгө, өр төлбөр, эзний өмчийг анхных нь ханшаар хөрвүүлдэг. Элэгдлийн зардал, хасагдуулгын зардал, борлуулалтын өртгөөс бусад орлого, зардлыг дундаж ханшаар хөрвүүлнэ.

Тухайн үеийн ханшны арга

Тухайн үеийн ханшны аргаар хөрвүүлэхэд балансын эзний өмчийн хэсгээс бусад бүх дүн тухайн үеийн солилцооны ханшаар, зөвхөн эзний өмч л анхны ханшаар (өөрөөр хэлбэл эзний өмчийг хүлээн зөвшөөрсөн өдрөөрх ханш) тусгагдана. Гадаад аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны албан ёсны валютынх нь талыг онцлон авч үзэх тохиолдолд, орлого зардлыг тухайн үеийн ханшаар, эсрэг тохиолдолд солилцооны дундаж ханшаар хөрвүүлнэ.

Цаг үеийн арга

Энэ аргын мөн чанар нь өнгөрсөн үеийн ханшаар илэрхийлэгдсэн анхны ханшаар, тухайн үеийн худалдан авах болон худалдах үнээр илэрхийлэгдсэн дансдыг тухайн үеийн ханшаар хөрвүүлэхэд оршдог. Мөнгөн хөрөнгө, авлага, өглөгийг тухайн үеийн ханшаар, бусад хөрөнгө болон эзэмшигчийн өмчийг анхны ханшаар хөрвүүлнэ. Бүх дансууд анхны өртгөөр илэрхийлэгдсэн тохиолдолд энэ аргын үр нөлөө хөрөнгө, эх үүсвэрийн шинж байдлаас хамааруулан хөрвүүлдэг аргатай ижил байна.

Санхүүгийн тайланг хөрвүүлэх дээрх аргуудыг харьцуулан хүснэгтээр харуулъя.

Хөрөнгө, өр төлбөр, эзэмшигчийн өмчийн дүнг хөрвүүлэхэд ашигласан ханш

Балансын дансууд	Тухайн үеийн ханшны арга	Хөрөнгө эх үүсвэрийн балансын ангиллын арга	Хөрөнгийн шинж байдлын арга	Үеийн арга
Хөрөнгө :				
Мөнгөн хөрөнгө	C	C	C	C
капитал үнэт цаас :				
өртгөөр илэрхийлэгдсэн	C	C	h	h

Тухайн үеийн зах зээлийн үнээр илэрхийлэгдсэн	C	C	h	C
Дансны болон векселийн авлага	C	C	C	C
Бараа материал :				
өртгөөр илэрхийлэгдсэн	C	C	h	h
Зах зээлийн үнээр илэрхийлэгдсэн	C	C	h	C
Урьдчилж гарсан зардал	C	C	h	h
Биет үндсэн хөрөнгө	C	h	h	h
Хуримтлагдсан элэгдэл	C	h	h	h
Биет бус хөрөнгө	C	h	h	h
Өр төлбөр ба эзэмшигчийн өмч :				
Дансны ба векселийн өглөг	C	C	C	C
Бондын өглөг, бусад урт хугацаат өр төлбөр	C	h	C	C
Гаргасан хувьцаа	h	h	h	h
Нэмж төлөгдсөн капитал	h	h	h	h
Хуримтлагдсан ашиг	Балансыг тэнцүүлэхэд ашигласан дүн			

C - тухайн үеийн ханш, h - анхны ханш

Хүснэгтээс үзэхэд балансын зүйлүүдийг хөрвүүлэхэд ялгаатай ханш хэрэглэж байгаа тул бал ансын дүн тэнцэхгүй. Иймд хөрвүүлэгдсэн хөрөнгө, эх үүсвэрийн дүнгийн зөрүүг балансын эх үүсвэр талын Эзэмшигчийн өмч хэсэгт "Хөрвүүлэлтийн тохируулга" (Translation adjustment) нэрээр тайлагнаж харуулна.

Гадаад дахь аж ахуйн нэгжийн санхүүгийн тайланг хэрхэн хөрвүүлэхийг жишээгээр авч үзье. 2000 оны 5 сарын 31-нд АНУ-ын үндэстэн дамнасан корпораци болох World компани, Венесуэллийн "Венесуэллийн санхүүжигч" нэртэй компанийн гүйлгээнд байгаа энгийн хувьцааны 30 хувийг олж эзэмшсэн. World компани хөрөнгө оруулалтаа 600000 В-аар олж авсан. В1= 0.25\$ гэсэн валютын худалдах спот ханшаар (Selling spot rate). Энэ нь 150000\$ гэсэн үг.

Хөрөнгө оруулалт хийгдсэн өдрөөрх гадаадын санхүүжигч компанийн хувьцаа эзэмшигчдийн капитал дараах байдалтай байв.

Энгийн хувьцаа	500000 В
Нэмж төлөгдсөн капитал	600000
Хуримтлагдсан ашиг	900000
Бүгд	2000000 В

2000000 * 0.30 = 600000 В (World компанийн хөрөнгө оруулалт)

"Венесуэлл – санхүүжигч" компанийн санхүүгийн тайланг албан ёсны мөнгөний нэгжээс Америкийн долларт хөрвүүлбэ.

2000 он 5.31	0.25\$ = 1В
2001 он 5.31	0.27\$ = 1В
2001 он 5.31 дуусч буй жилийн дундаж	0.26\$ = 1В

“Венесуэлл – санхүүжигч” компани
Санхүүгийн тайланг долларт хөрвүүлэх нь
 2001 оны 05 сарын 31-ээр дуусч буй он.

Орлогын тайлан	Венесуэллийн боливар	Ханш	Ам.доллар
Цэвэр борлуулалт	B 6000000	\$0.26(1)	\$1560000
Өртөг ба зардал	4000000	0.26(1)	1040000
Цэвэр ашиг	2000000		520000
	Хуримтлагдсан ашгийн тайлан		
Хуримтлагдсан ашиг C ₁	900000	0.25(2)	225000
Нэмэх нь: Цэвэр ашиг	2000000	0.26	520000
ДҮН	2900000		745000
Хасах нь: Ногдол ашиг	600000	0.27(3)	162000
Хуримтлагдсан ашиг C ₂	2300000		583000
Баланс			
Хөрөнгө:			
Эргэлтийн хөрөнгө	200000	0.27(3)	54000
Үндсэн хөрөнгө (цэвэр)	4500000	0.27(3)	215000
Бусад хөрөнгө	300000	0.27(3)	81000
Хөрөнгийн дүн	<u>5000000</u>		<u>1350000</u>
Өр төлбөр ба ХЭКап:			
Богино хугацаат өр төлбөр	100000	0.27(3)	27000
Урт хугацаат өр	1500000	0.27(3)	405000
Энгийн хувьцаа	500000	0.25(2)	125000
Нэмж төлөгдсөн капитал	600000	0.25(2)	150000
Хуримтлагдсан ашиг	2300000		583000
Хөрвүүлэлтийн тохируулга			60000
Өр төлбөр, ХЭК дүн	<u>5000000</u>		<u>1350000</u>

(1) 2001 оны дундаж ханш

(2) Анхны ханш (World-н ХО хийсэн өдрөөрх)

(3) Тухайн үеийн ханш (2001 оны 5-31-ээрх)

- Бүх хөрөнгө, өр төлбөр тухайн үеийн ханшаар хөрвүүлэгдэж байна.
- Төлөгдсөн нийт капитал, энгийн хувьцаа, НТК, хуримтлагдсан ашгийн эхний үлдэгдэл World компанийн ХО хийсэн өдрөөрх буюу анхны ханшаар
- Орлогын тайлан дахь бүх орлого, зардлууд дундаж ханшаар
- Хөрвүүлэлтийн тохируулга нэртэй үзүүлэлт хөрвүүлэгдсэн балансын хувьцаа эзэмшигчдийн капитал хэсэгт тусгагдана.

“Венесуэлл–Санхүүжигч”-н санхүүгийн тайланг В-с \$-т хөрвүүлсний дараа World, энгийн хувьцаагаарх ХО-аа капиталын арга ашиглан \$-р дараах байдалтай журналд тусгана.

- “Венесуэлл–санхүүжигч”-д оруулсан
 Энгийн хувьцаагаарх ХО (520000 * 0.30) 156000
 ХО-ын орлого 156000
- Ноогдол ашгийн авлага (162000 * 0.30) 48600
 “Вен–сан”-д оруулсан э/х – х ХО 48600

Эдгээр бичилтийн дараа World компанийн ХО - дансны үлдэгдэл =150000\$ + 156000\$ - 48600\$ = 257400\$ болох ба энэ нь “Венесуэлл–Санхүүжигч” компанийн хөрвүүлэгдсэн баланс дахь хувьцаа эзэмшигчдийн капиталаас World компанийн хүртэх хувьтай тэнцүү байна. Ийнхүү гадаад дахь аж ахуйн нэгжүүдийн (салбар, хэсэг, хараат охин компани) санхүүгийн тайланг хөрвүүлэхдээ дээрх боломжит аргуудыг ашиглаж болох бөгөөд, ингэхдээ “Валютын ханшны өөрчлөлтийн үр дагавар” хэмээх НББОУС-21-д тодорхойлсон шаардлагад бүрэн нийцүүлэх ёстой.